



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/494

Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 45 дугаар зүйлийн 45.1, 2023 оны Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187, 2023 оны А/133 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Ц.Хонгорын ирүүлсэн хүсэлтийн дагуу аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/52 дугаар захирамжаар аймгийн инженерийн шугам сүлжээтэй бүс тэлсэнтэй холбогдуулан газрын гэрчилгээг шинэчлэн гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 29 нэгж талбарын хавсралтын 10 дугаар заалтад иргэн Цогхүүгийн Хонгор (РЮ90011317)-ын "төмс, хүнсний ногооны зориулалттай"-гаар эзэмшүүлсэн газрын зориулалт алдаатай гарсан байх тул алдааг засаж Мөрөн сумын 13 дугаар баг "Гахай тахианы хонхор"-т байршилтай 6712017291 нэгж талбарын дугаартай 3595м² газрын зориулалтыг өөрчилж, "гэр орон сууцны хашааны газар" болгон үлдсэн 2 жилийн хугацаатайгаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигч иргэн Цогхүүгийн Хонгор (РЮ90011317)-той газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Ш.Дамдиндорж)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Захирамж-2023

6712011074